



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 88

Чойбалсан

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын "ж" дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн иргэдийн англи хэлний боловсролыг дээшлүүлэх "Англи хэлтэй Дорнодчууд" хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган, хэрэгжилтийг ханган, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /М.Бадамсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



М.ЭНХТӨР

“Англи хэлтэй - Дорнодчууд” хөтөлбөр

Нэг. Үндэслэл

Улс хоорондын болон олон улсын түвшинд англи хэлний гүйцэтгэх үүрэг, хэрэглээ эрс өсч интернет мэдээллийн 70% англи хэлээр түгээгдэж, худалдаа бизнес, аялал жуулчлалын гол хэл англи хэл болж байгаа ба дэлхийн шилдэг 500 гаруй их, дээд сургууль англи хэлээр үйл ажиллагаа явуулж байна. Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургуулийн суурь боловсролын англи хэлний сургалтын чанар улсын дунджаас 10 хувь доогуур үзүүлэлттэй байна.

Иймд ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний сургалтын чанарыг дээшлүүлэх, англи хэлийг аль ч түвшинд мэдээлэл харилцаа, ажил хэргийн гол хэрэгсэл болгон хөгжүүлэх, суралцах хэрэгцээ шаардлага бий болж байна.

Хоёр. Хэрэгжүүлэх хугацаа – 2021-2024 он

Гурав. Зорилго:

Англи хэл сурах бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлж, англи хэлийг мэдээлэл, харилцаа, ажил хэргийн хэрэгсэл болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино

Дөрөв. Зорилт:

4.1. Англи хэлний багш нарын ур чадварыг нэмэгдүүлж, англи хэлний сургалтын чанарыг улсын дундаж түвшинд хүргэнэ.

4.2. “Англи хэлтэй-Дорнодчууд” аян өрнүүлж, англи хэлний сургалт зохион байгуулах иргэн, сургалтын төвүүдтэй хамтран ажиллаж, англи хэлтэй иргэд, оюутан залуучууд, төрийн албан хаагчдын тоог нэмэгдүүлнэ

Тав. Хэрэгжүүлэх байгууллага: Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар, Дорнод их сургууль, сургалтын байгууллагууд, Ерөнхий боловсролын сургуулиуд,

Зургаа: Санхүүгийн эх үүсвэр:

1. Улсын болон аймгийн төсөв, аймгийн орон нутгийн хөгжлийн сан
2. Гадаад улс, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн дэмжлэг, тусламж
3. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж иргэдийн хандив, тусламж
4. Бусад

Шаардагдах төсөв: Нийт 90.000.000 төгрөг /Ерэн сая/
2021 онд- 15.0 сая, 2022 онд 20.0 сая, 2023 онд 25.0 сая, 2024 онд 30 сая,

Долоо: Хүлээгдэж буй үр дүн:

- Англи хэлний багш нарын мэргэжлийн ур чадвар дээшилж, англи хэл заах хүний нөөцийн чадавх дээшилсэн байна.

- Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний сургалтын чанар улсын дундаж түвшинд хүрсэн байна.
- Англи хэлтэй хүүхэд, оюутан залуучууд, төрийн албан хаагчид, иргэдийн тоо өсч, ярианы чадвар дээшилсэн байна.
- Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн мэдээлэл авах боломж дээшилж, орон нутгийн аялал жуулчлал, бизнес эрхлэх боломж нэмэгдсэн байна.

Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:

1. Англи хэлний сургалтын чанар,
2. Англи хэлний сургалтын байгууллагын тоо, үйлчилгээний хүртээмж
3. Сургалт, судалгаа, ажил үйлчилгээнд англи хэлийг ашиглаж буй албан хаагч, багш, сурагч, оюутан, иргэдийн тоо
4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцооны өсөлт

Ес. Хөтөлбөрийн тайлан, Хяналт, шинжилгээ үнэлгээ, удирдлага зохион байгуулалт

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг орон нутагт бусад төсөл хөтөлбөртэй уялдуулан зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах арга хэмжээг аймгийн Боловсрол, соёл урлагийн газар хариуцан зохион байгуулна.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага арга зүйгээр хангах, хяналт тавих, шаардагдах төсөв хөрөнгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлнэ.

3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёл урлагийн газар нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр танилцуулна.

Арав. Хөтөлбөрийн зорилтыг хангах арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтрах талууд
Зорилт 1. Англи хэлний багш нарын ур чадварыг нэмэгдүүлж, англи хэлний сургалтын чанарыг улсын дундаж түвшинд хүргэнэ				
1	Англи хэлний боловсролын үйлчилгээ үзүүлдэг олон улсын байгууллага, сургалтын төв, сонирхогч талуудтай холбоо тогтоон "Англи хэлтэй Дорнодчууд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтарсан арга хэмжээг зохион байгуулах	Жил бүр	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар	Англи хэлний боловсролын үйлчилгээ үзүүлдэг олон улсын байгууллага, сургалтын төв, сонирхогч талууд,
2	Англи хэлний сургалтын орчинг стандартын шаардлагад нийцсэн техник, тоног төхөөрөмж, ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах	2021-2024 он	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар	Номын сан, Ерөнхий боловсролын сургууль, сургалтын байгууллагууд
-3	Англи хэлний сургалтад багш нарыг хамруулах	2021-2022	Боловсрол, соёл урлагийн газар	Багш нар

4	Ахлах ангийн 12дугаар ангийн суралцагчдын дунд “Хэлтэй бол хэлтэй” англи хэлний яриа, эссе бичгийн тэмцээн зохион явуулах.	Жил бүр	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар	Дорнод их сургууль, Сургалтын төв, Ерөнхий боловсролын сургуулиуд
5	“Зөвхөн англиар ярилцъя” зуны сургалт зохион байгуулах	Жил бүр	Боловсрол, соёл урлагийн газар, Дорнод их сургууль	Олон улсын байгууллагууд, Сургалтын төв, багш нар
6	Суурь, бүрэн дунд боловсролын англи хэлний түвшин тогтоох шалгалт авах	Жил бүр	Боловсрол, соёл урлагийн газар	Ерөнхий боловсролын сургуулиуд

Зорилт 2. “Англи хэлтэй-Дорнодчууд” аян өрнүүлж, англи хэлний сургалт зохион байгуулах иргэн, сургалтын төвүүдтэй хамтран ажиллаж, англи хэлтэй иргэд, оюутан залуучууд, төрийн албан хаагчдын тоог нэмэгдүүлнэ

1	Төрийн албан хаагчдад англи хэлний мэдлэг чадвар олгох сургалт /онлайн болон танхимын/	Жил бүр	Сургалтын төвүүд	Төрийн байгууллагууд, Багш нар
2	Аялал жуулчлал, бизнес эрхлэгчдэд зориулсан англи хэлний сургалт /онлайн болон танхимын/	Жил бүр	Дорнод их сургууль	Сургалтын төв, багш нар
3	Орон нутгийн иргэд, залуучуудад “Англиар ярилцъя” ярианы клуб хичээллүүлэх	Жил бүр	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Залуучуудын хөгжлийн төв, багш нар
4	“Үг цээжлэе” уралдаан	Жил бүр	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Дорнод их сургууль	Төрийн байгууллагууд
5	“Англи хэл сурах арга зүй” уулзалт, онол практикийн бага хурал	2021, 2023 онд	Боловсрол, соёл урлагийн газар, Дорнод их сургууль	Сонирхогчид
6	“Англи хэлтэй-Дорнодчууд” орон нутгийн телевизээр англи хэл дээр мэдээ хийх	7 хоногт 2 удаа	Боловсрол, соёл урлагийн газар, Дорнод их сургууль	Орон нутгийн нэг ТВ-тэй гэрээ байгуулна
7	Тайлан танилцуулах, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх	Жил бүр	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар	Хамтрагч талууд
8	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах	тогтмол	Боловсрол, соёл урлагийн газар	Орон нутгийн ТВ болон сонин